ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/142/НА-СА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2022 он | Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр<br>Утас: 70378845 Цахим хаяг:munkhbayarsh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Сувдмаа<br>Утас: 70373089 Цахим хаяг: Suvdmaakh@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА С.ЭНХБОЛД ТАНАА

2022.02.25 № 127

танай ______ -ны № ______ -т

01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шаардагдах этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.МӨНХБАЯР

009020131

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

*(төгрөгөөр)*

| Дансны код | Балансын үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|---|
| **Санхүүгийн байдлын тайлан** | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 78,255,646.58 | 81,834,314.58 |
| | Мөнгөн хөрөнгө | | |
| | Авлага | | - |
| | Бараа материал | 78,255,646.58 | 81,834,314.58 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 1,668,486,519.01 | 1,566,727,265.00 |
| | **Нийт хөрөнгийн дүн** | **1,746,742,165.59** | **1,648,561,579.58** |
| | Нийт өр төлбөрийн дүн | - | - |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,746,742,165.59 | 1,648,561,579.58 |
| | **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,746,742,165.59** | **1,648,561,579.58** |
| **Санхүүгийн үр дүнгийн тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | 827,527,144.00 | 741,249,900.00 |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | 886,523,170.99 | 823,111,819.71 |
| | **Үйл ажиллагааны үр дүн** | **(58,996,026.99)** | **(81,861,919.71)** |
| | Үнэ төлбөргүй гарсан зардал | 72,119,800.00 | 14,026,900.00 |
| | Үнэ төлбөргүй гарсан бараа материал | | 2,235,000.00 |
| | Хөрөнгийн зардал | 38,139,613.00 | |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | (110,259,413.00) | (16,261,900.00) |
| | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **(169,255,439.99)** | **(98,123,819.71)** |
| **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** | | | |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 436,714,893.47 | 1,746,685,399.29 |
| | Тайлант оны үр дүн | | **(98,123,819.71)** |
| | **Эцсийн үлдэгдэл** | **436,714,893.47** | **1,648,561,579.58** |
| **Мөнгөн гүйлгээний тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 739,139,454.00 | 708,268,900.00 |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 739,139,454.00 | 708,518,900.00 |
| | **Үйл ажиллагааны ЦМГ** | | **3,750,000.00** |
| | Биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 3,750,000.00 |
| | **Хөрөнгө оруулалтын ЦМГ** | | **(3,750,000.00)** |
| | **Санхүүгийн ажиллагааны ЦМГ** | | |
| | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | | |
| **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | | | |
| | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **708,946,700.00** | **697,481,903.00** |
| | Урсгал зардал | 708,946,700.00 | 697,481,903.00 |
| | Хөрөнгийн зардал | | |
| | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **708,946,700.00** | **697,481,903.00** |
| | Улсын төсвөөс санхүүжих | 660,370,700.00 | 658,033,703.00 |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос | 47,760,000.00 | 38,632,200.00 |
| | Урсгал шилжүүлэг | 816,000.00 | 816,000.00 |

## Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь Иргэндээ үйлчилдэг төрийн албаны соёлыг төлөвшүүлэх зорилгын дор 3 зорилт, 13 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

## Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## Дөрөв. Аудитын гол асуудал

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

**Долоо. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 77,573.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд санхүүгийн тайланд 4,178.1 мянган төгрөгийг залруулж, 72,306.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,088.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**4.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн үр дүнгийн тайланг 428.1 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 3,750.0 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгийн зардлыг зөрүүтэй тайлагнасныг залруулав.

**4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоох асуудал гараагүй болно.

**4.3 Албан шаардлага**

1.Тус газар нь БНСУ-д NEAR холбооны олон улсын байгууллагад 2 жилийн гэрээ байгуулан ажиллаж байгаа мэргэжилтэн Б.Мөнхцэцэгт 5,234,582.0 төгрөгийн цалин, НДШ-д 1,041,051.0 төгрөгийг олгосонд цаашид зогсоох албан шаардлага хүргүүлэв

2. Өмнөх онд өгсөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүйд албан шаардлага хүргүүлэв.

**4.4 Зөвлөмж**

**Цалингийн зардалтай холбоотой асуудал**

*<u>1,1 Илрүүлэлт:</u>*

Тайлант онд байгууллагын үйлчилгээний ажиллагсдад ур чадварын нэмэгдлийг олгохдоо ажлын үр дүнг тодорхой шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй, хавтгайруулан олгосон.

*<u>1.2 Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалын хавсралт 4-т заасныг хэрэгжүүлж ажиллах

*<u>1,3 Илрүүлэлт:</u>*

Байгууллагын 2021 оны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас Аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар дарга С.Энхболдод 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,088.6 мянган төгрөгийн мөнгөн шагналыг олгосон.

*<u>1.4 Өгсөн зөвлөмж</u>:*

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2014 онд баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

## 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

## 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 4 | 11.6 | 1 | 4.2 | | | 1 | 6.3 | 2 | 1.1 |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | | | |
| | Дүн | 4 | 11.6 | 1 | 4.2 | | | 1 | 6.3 | 2 | 1.1 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 1 | 66.0 | | | | | 1 | 66.0 | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | | | |
| | Дүн | 1 | 66.0 | | | | | 1 | 66.0 | | |
| | **НИЙТ ДҮН** | **5** | 77.6 | **1** | **4.2** | | | **2** | 72.3 | **2** | **1.1** |